



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



СУУРЬ БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

МОНГОЛ ХЭЛ

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

МОНГОЛ ХЭЛ

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрх зүйн баримт бичгүүд	6
Боловсролын үнэлгээ	16

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

МОНГОЛ ХЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. VI АНГИ

1.1. VI ангийн монгол хэлний хичээлийн суралцахуйн үр дүн.....	21
1.2. Үнэлгээний нэгж	21
1.2.1. Үнэлгээний нэгж 1. Хүүрнэсэн эхийг задлан шинжилж нэгтгэн дүгнэх.....	21
1.2.2. Үнэлгээний нэгж 2. Хүүрнэсэн эх зохиож бичих	22
1.2.3. Үнэлгээний нэгж 3. Хүүрнэсэн эхийг дэлгэрүүлэх.....	23
1.2.4. Үнэлгээний нэгж 4. Харилцан ярих	24
1.2.5. Үнэлгээний нэгж 5. Хэл зүйн шинж, хэрэглээ	24

ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ

2.1. VII ангийн монгол хэлний хичээлийн суралцахуйн үр дүн	27
2.2. Үнэлгээний нэгж	27
2.2.1. Үнэлгээний нэгж 1. Тоочсон эхийг уншиж ойлгох	27
2.2.2. Үнэлгээний нэгж 2. Тоочин дүрсэлсэн эх зохиож бичих.....	28
2.2.3. Үнэлгээний нэгж 3. Зөв бичих.....	30
2.2.4. Үнэлгээний нэгж 4. Хэлзүй	30
2.2.5. Үнэлгээний нэгж 5. Харилцан ярих	32

ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

3.1. VIII ангийн монгол хэлний хичээлийн суралцахуйн үр дүн.....	33
3.2. Үнэлгээний нэгж	33
3.2.1. Үнэлгээний нэгж 1. Тоочсон эхийг уншиж ойлгох	33
3.2.2. Үнэлгээний нэгж 2. Тайлбарласан эх зохион бичих	35
3.2.3. Үнэлгээний нэгж 3. Харилцан ярих	36
3.2.4. Үнэлгээний нэгж 4. Хэлний хэрэглээ	36

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IX АНГИ

4.1. IX ангийн монгол хэлний хичээлийн суралцахуйн үр дүн	38
4.2. Үнэлгээний нэгж	38
4.2.1. Үнэлгээний нэгж 1. Тайлбарласан эхийн үндсэн шинжийг ялган таньж, тодруулах	38
4.2.2. Үнэлгээний нэгж 2. Тайлбарласан эхийн онцлогийг тодорхойлж тайлбарлах	38
4.2.3. Үнэлгээний нэгж 3. Эхийн үгийн санг харьцуулах	40
4.2.4. Үнэлгээний нэгж 4. Асуудал дэвшүүлэн таамаглаж тайлбарлан бичих ...	40
4.2.5. Үнэлгээний нэгж 5. Найруулгын алдаагүй бичих.....	41
4.2.6. Үнэлгээний нэгж 6. Цэг, цэглэлийг хэрэглэх.....	42
4.2.7. Үнэлгээний нэгж 7. Үзэл бодлоо илэрхийлэх.....	43



МЭНДЧИЛГЭЭ

**Эрхэм баян-эрдэм мэдлэгийг түгээн
дэлгэрүүлэгч эрдэмтэн багш нар аа!**

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд зохицон амьдрах хувь хүний эрэлтийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэхэд дэлхийн улс орнууд ихээхэн анхаарч, боловсролын тогтолцоогоо улам бүр боловсронгуй болгож байна.

Сургалтын хөтөлбөрт суралцагчийн суралцах чадварын хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, аливаа зүйлийг судлах сонирхол, идэвх зүтгэлд гарч буй ахиц амжилтыг үнэлэхээр үнэлгээний зорилтыг тодорхойлсон бөгөөд суралцагчийн үнэлгээний журамд “үнэлгээ нь шалгуурт суурилсан” байхаар заасан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/180 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн боловсруулж, баталлаа.

Энэхүү шалгуур үзүүлэлт батлагдсанаар суралцагчийн ахиц амжилтыг ижил шалгуураар үнэлэх /суралцагчдын ялгаатай байдлыг тодорхойлох/, хичээлийн бэлтгэлийг чанартай хангах /нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт хийх/ зэрэг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах, эргэх холбоотой ажиллах боломж бүрдэх юм.

Оюунлаг, чадварлаг, бүтээлч шинэ эриний “Монгол хүн” бүтээх гол цөм, тулах цэг нь болсон багш, боловсролын ажилтан та бүхэнд эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад оролцсон эрдэмтэн багш, судлаач нар болон техникийн дэмжлэг үзүүлсэн Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, Дэлхийн банкны “Бага боловсролын шинэчлэл” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН
Боловсрол, шинжлэх ухааны сайд



МЭНДЧИЛГЭЭ

Боловсролын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаа эрдэмтэн багш, боловсролын ажилтан, судлаачид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Суралцагчдад хаана, ямар орчинд суралцаж байгаагаас үл хамааран ижил шалгуур, ижил арга, аргачлалаар сурлагын амжилт, ахицаа бодитой тодорхойлуулах хэрэгцээ ямагт байдаг. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг бодитой, шинжлэх ухаанчаар үнэлж дүгнэн үнэлгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд үр нөлөөтэйгээр хэрэглэх нь манай орны төдийгүй дэлхийн улс орнуудын багш нарт ч сорилт хэвээр байна.

2018 онд БСШУС-ын (хуучнаар) сайдын А/425 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д суралцагчийн үнэлгээг шалгуурт суурилсан бөгөөд суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сурлагын ахиц, амжилтыг дэмжиж, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байхаар тодорхойлсон нь дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэлгээний шалгуур нь хичээл, сургалтын үр дүнд суралцагчийн юу мэддэг, юу чаддаг, яаж хийж хэрэглэх ёстойг тодорхойлж өгсөн суралцахуй, багшлахуйн ач холбогдолтой “үнэлгээний гол хэрэгсэл” юм. Багш та үнэлгээний шалгуурыг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэснээр суралцагчийн гүйцэтгэлд тулгуурлан сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийн талаар бодитой, үр нөлөөтэй үнэлэлт, дүгнэлт хийж тэдэнд ямар дэмжлэг, хэрхэн үзүүлэхээ тодорхойлох бүрэн боломж бүрдэнэ.

Боловсролын үнэлгээний төв нь хичээл тус бүрээр эрдэмтэн, багш, судлаачдын баг бүрдүүлэн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр үнэлгээний нэгжийн түвшинд анх удаагаа боловсруулж та бүхний гар дээр хүргэж байна.

Үнэлгээний шалгуурыг олон улсын түвшинд боловсролын үнэлгээ, тэр дундаа суралцагчийн үнэлгээ, үнэлгээний шалгуур чиглэлээр баримталж буй онол, үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуйн онцлогийг харгалзан боловсруулсан.

Боловсролын үнэлгээний тогтолцоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах эрхэм багш та бүхний үйлс нь улам өөдөө байж, боловсролын хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэл нэгдэн урагшилна гэдэгт итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Лхагвасүрэнгийн ГАНБАТ
Захирал

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ТУШААЛ



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 07 сарын 23-ны
өдрийн 3967 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам, загвар шинэчлэн батлах тухай” А/309 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД




Ц.ЦОГЗОЛМАА

0001553

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
А/425 дугаар тушаалын хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН БОЛОН СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүн, төлөвшлийг үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт, чанарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтыг үнэлж, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтад тохируулга хийх; анги дэвших болон сургууль төгсөх шалгалт /цаашид "улсын шалгалт" гэх/ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах; чанарын үнэлгээ нь боловсролын чанар, үр дүнг тодорхойлж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тус тус чиглэнэ.

Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1. Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.2. Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

2.3. Анги дэвших болон улсын шалгалтын сэдэв, даалгавар нь танин мэдэхүйн түвшинд нийцсэн, тохирц, найдварыг шалгасан, нууцлалыг хадгалсан, шалгуулагчдыг хүндэтгэсэн, найдвартай байх.

Гурав. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. "Шалгуурт суурилсан үнэлгээ" нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

3.4. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

3.10. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

3.11. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд дараах 8 түвшинтэй байна.

Түвшин	Үнэлгээ, хувиар	Үнэлгээний түвшний шалгуур
VIII	90-100	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтлыг бүрэн ойлгож, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, санал гаргах түвшинд эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг
VII	80-89	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль, зүй тогтол, хоорондын хамаарлыг ойлгож эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил бус нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгодог - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ оновчтой илэрхийлдэг
VI	70-79	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөдөг - Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг
V	60-69	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчим, хуулийг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах, төлөвлөхөд оролцдог - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах тохирох аргыг сонгодог - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, гол санааг илэрхийлдэг
IV	50-59	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг бүрэн ойлгосон. - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нөхцөлд хэрэглэдэг - Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлж, шинжлэн судлах үйлд оролцдог. - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг. - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

III	40-49	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг ойлгох, тайлбарлах түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг • Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг • Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг
II	30-39	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх, цээжлэх түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг
I	0-29	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн

3.12. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.13. III-XII ангийн суралцагчийг бүлэг сэдвийн төгсгөлд, хичээлийн жилийн II, IV улирлын эцэст тус тус багш үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүн /хувь/-г ангийн журналд тэмдэглэнэ. IV улирлын эцэст хийсэн үнэлгээ /хувь/ нь жилийн эцсийн дүн байна.

3.14. III-XII ангийн жилийн эцсийн дүн болон анги дэвших, улсын шалгалтын дүнг ангийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт анги удирдсан багш тус тус тэмдэглэнэ.

3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна.

3.16. Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ.

3.17. Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.18. Суралцагчийн төлөвшилийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажилд оролцсон байдал, идэвх санаачилгын талаарх хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дараах чиглэлээр дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт бичнэ.

- санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал;
- бие даан сурах арга барил, бусадтай хамтран ажиллах;
- шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо;
- соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал;
- хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт;
- шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт.

3.19. Анги удирдсан багш суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийн үнэлгээний талаарх дүгнэлт, саналыг хичээлийн жилийн II, IV улирлын эцэст эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.20. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ.

Дөрөв. Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт

4.1. Анги дэвших шалгалт нь суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтооход чиглэнэ.

4.2. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуурын дагуу дараах чиглэлээр журмын 3.9-д заасан хэлбэрээс сонгож анги дэвших шалгалтыг зохион байгуулна.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл
Бага боловсрол	III	1	Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/
	IV	2	- Сургууль сонгох 1 хичээл - Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/
Суурь боловсрол	VI	2	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл
	VII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
	VIII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
Бүрэн дунд боловсрол	X	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/
	XI	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/

4.4. Журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуур болон “Анги дэвших шалгалтын бюпринт” /цаашид бюпринт гэх/, шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх маягт, зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ерөнхий боловсролын сургуульд хүргүүлнэ.

4.5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлж, өмчийн бүх хэлбэрийн сургуульд хүргэх, түүнийг хэрэглэх арга зүйгээр хангах ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулна.

4.6. Анги дэвших болон улсын шалгалт зохион байгуулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон “Шалгалтын комисс” зохион байгуулна. Комиссын дарга нь сургуулийн захирал байх бөгөөд сургалтын менежер, багш, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулна. Комиссын гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл шалгалтын сэдэв, даалгавар боловсруулахад оролцохгүй.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

4.7. Энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7.1. анги дэвших шалгалт зохион байгуулах удирдамж, дэг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.7.2. анги дэвших шалгалттай холбогдон гарсан аливаа гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэх;

4.7.3. шалгалтын үнэлгээ, дүн мэдээг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, маягтын дагуу нэгтгэн, шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдамжаар хангах, хяналт тавих.

4.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, сургууль бүрд зөвлөмж боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын дүнд үндэслэн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.10. Сургууль энэхүү журмын 4.8-д заасан зөвлөмжид үндэслэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.

Тав. Улсын шалгалт, түүний зохион байгуулалт

5.1. Улсын шалгалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийхэд чиглэнэ.

5.2. Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно.

5.3. Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангийн суралцагч дараах хичээлээр улсын шалгалт өгнө.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын агуулга
Бага боловсрол	V	3	1. Монгол хэл 2. Математик 3. Хүн ба байгаль
Суурь Боловсрол	IX	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно./ • Байгалийн ухааны нэгдмэл агуулга • Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/ 4. Гадаадхэл /англи хэл, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/
Бүрэн дунд боловсрол	XII	4	1. Монголхэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/ 4. Гадаад хэл /англи, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/

5.4. Улсын шалгалтын товыг боловсролын үнэлгээний байгууллагаас жил бүр тогтоох бөгөөд шалгалтыг улсын хэмжээнд зэрэг эхлүүлж, дуусгана.

5.5. Улсын шалгалтын үнэлгээг энэхүү журмын 3.11-д заасан үнэлгээгээр үнэлнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

5.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь "Улсын шалгалтын бюлпринт" /цаашид бюлпринт" гэх/, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг жил бүрийн 5 дугаар сарын 15- ны өдрийн дотор баталгаажуулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

5.8.Боловсролын үнэлгээний байгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн "Даалгаврын нээлттэй сан" /цаашид "даалгаврын сан" гэх/ бүрдүүлэх, шинэчлэх, баяжуулалт хийх ажлыг хариуцна.

5.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь "Улсын шалгалтын комисс"- ыг жил бүрийн 5 дугаар сарын 01 -ний өдрийн дотор байгуулна. Энэхүү комисс нь тухайн орон нутагт улсын шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

5.10. Сургууль дээр улсын шалгалт зохион байгуулахтай холбогдуулан энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.10.1.улсын шалгалтын удирдамж, дэгийг боловсруулж, шалгалтыг зохион байгуулах;

5.10.2.шалгалт эхлэхээс 1 өдрийн өмнө энэхүү журмын 5.7-д заасан бюлпринт, зөвлөмжийн дагуу улсын шалгалтын сэдэв боловсруулж, нууцлалыг хариуцах;

5.10.3.шалгалтын дүн мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих;

5.10.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэх;

5.10.5.улсын шалгалттай холбогдон гарсан аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх;

5.10.6.шалгалтын материал, тайланг сургуулийн архивт хүлээлгэн өгөх.

5.11.Шалгалт зохион байгуулах хугацаанд улсын болон олон улсын уралдаан, тэмцээнд оролцсон суралцагчийн улсын шалгалтын үнэлгээг нотлох баримтад үндэслэн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

5.12.Суралцагч өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шалгалт өгөөгүй эсвэл дутуу өгсөн тохиолдолд улсын шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээгээр тооцож болно.

5.13.Боловсролын үнэлгээний байгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинжилгээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.14.Журмын 5.9-д заасан "Улсын шалгалтын комисс" нь улсын шалгалт зохион байгуулсан тайланг нэгтгэн, шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Чанарын үнэлгээ, түүний зохион байгуулалт

6.1.Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

6.2.Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллага зохион байгуулна.

6.3.Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна.

6.4.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээ зохион байгуулах товыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтооно.

6.5.Чанарын үнэлгээг зохион байгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хамтран жил бүрийн 01 дүгээр сард багтаан тогтооно.

6.6.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, аргачлалыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

6.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээний өгөгдлийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, тайлан, санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.8.Чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн энэхүү журмын 6.7-д заасан байгууллага бодлого боловсруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.

6.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага чанарын үнэлгээний тайланд үндэслэн сурлагын амжилтыг сайжруулах төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.10.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

Долоо. Бусад

7.1.Аливаа төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөшлийг үнэлэх, шалгалт зохион байгуулахыг хориглоно.

---оОо---

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН А/180 ТУШААЛ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/425 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хавсралтаар баталсугай.

2. Суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг энэхүү тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур"-ыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үнэлсүгэй.

3. Шалгуурын дагуу үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжийг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатарт даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142110643

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ
(*Student assessment*)

Сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц;

ШАЛГУУР
(*Criteria*)

Зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин;
(UNESCO-CEPES, 2007)

ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР
(*Assessment criteria*)

Суралцахуйн үр дүнд хүрэхэд шаардлагатай тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог.

ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ
(*Diagnostic assessment*)

Хичээл, сургалтын эхэнд суралцагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг тандах зорилгоор хийгдэх үнэлгээ;

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ
(*Formative assessment*)

Багш, суралцагчийн зүгээс суралцагчийн “суралцахуй”-г танин мэдэх, хариу үйлдэл үзүүлэх зорилгоор сургалтын явц /ээлжит хичээл/-д хийгдэх үнэлгээ;

ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ
(*Summative assessment*)

Хичээл, сургалт /нэгж, хагас жил, жилийн эцэст г.м тодорхой хугацааны/-ын дараа үнэлгээний шалгуурт хүрсэн байдлыг тогтоож, цаашид суралцахуй болон багшлахуйд анхаарах зүйлийг тодорхойлох зорилгоор хийгдэх үнэлгээ;

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээ нь суралцах үйл ажиллагаа/суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Хичээл сургалтын явцад багш нар суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт (сорилго¹) авах, засах (хэмжилт хийх²/), үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажлууд нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг сайн хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, шалгалтын үр дүнд хэрхэн дүн шинжилгээ хийх, хэрхэн үнэлж дүгнэхээ хангалттай сайн хийдэггүй. Иймээс үнэлгээг “бүрэн бус” хийдэг бөгөөд зөвхөн дүн тавихын тулд шалгалт авдаг гэсэн тогтсон ойлголт хандлага давамгайлдаг.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Суралцагчийн үнэлгээ нь тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүнг тодорхойлсон “шалгуур”-т суурилсан байна. Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ шалгуурт суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгууртай (хүрэх үр дүнтэй) харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг;
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл;
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой;

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултуудын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариултыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Энгийнээр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын үр дүнд суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Үнэлгээний шалгуур нь суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох;
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх;
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаар мэдээллийн сан үүсэх;
- Суралцахуйг дэмжих арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх;
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох;

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцнэ. Үүнд:

- Үнэлгээний шалгуур нь давхцаагүй, нэг нэгнээсээ ялгаатай байх;
- Үнэлгээний шалгуур нь боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх;
- Үнэлгээний шалгуур нь ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулагдсан байх;
- Оролцогч бүх талууд /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичигдсэн байх;
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх; Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, хэлэлцэх, тайлбарлах, урьдчилан таамаглах, үнэлэх, харьцуулах, үнэлэх, шүүмжлэх зэрэг нь тохиромжтой үйл үгс болно.
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байх ёстой учраас үр дүнгийн тодорхойлолт тус бүрд сонгож авсан үгс нь ажиглагдаж, хэмжиж болох зан үйлийг бий болгох үйл үг юм.


ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс" судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник тусалцааны төсөл, 2017 он.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР



СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

МОНГОЛ ХЭЛ

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэгдүгээр бүлэг - VI анги

Хоёрдугаар бүлэг - VII анги

Гуравдугаар бүлэг - VIII анги

Дөрөвдүгээр бүлэг - IX анги

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. VI АНГИ

1.1. VI АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч нь хүүрнэсэн эхийг задлан шинжилж, үндсэн шинжээр нь ялган таньдаг, цаг хугацааны дарааллаар хүүрнэн бичихдээ жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэрийн утга, бүтэц, үгийн сангийн мэдлэгээ ашигладаг, эх хэлний баялаг санг судлан эзэмших хүсэл эрмэлзэлтэй болно.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

1.2.1. Үнэлгээний нэгж 1. Хүүрнэсэн эхийг задлан шинжилж нэгтгэн дүгнэх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
6.1а. Алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, үйл явдлын мэдээ зэрэг эхийн орон цагийн дараалал, учир шалтгааны уялдаа холбоо, бүтцийг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних	Сурагч уншсан хүүрнэсэн эхийг задлан шинжилж, үндсэн шинжээр нь ялган таньдаг болно. /алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, үйл явдлын мэдээ, богино өгүүллэг, үлгэр/.
6.1б. Богино өгүүллэг, үлгэр зэрэг эхийн бүтэц, учир шалтгааны уялдаа холбоо, орон цагийн дарааллыг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних	
6.1г. Уншсан эхийн орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлох	
6.1в. Хүүрнэсэн эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн уялдаа холбоог тогтоож, эхийн сэдэв, гол санааг тодорхойлох	
6.1з. Үйл явдлын мэдээ, мэдээллийг нэгтгэж дүгнэж унших	
6.1ж. Уншсан эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлах	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч уншсан хүүрнэсэн эхийг задлан шинжилж, үндсэн шинжээр нь ялган таньдаг болно /алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, үйл явдлын мэдээ, богино өгүүллэг, үлгэр/	Сурагч уншсан эхийн бүтэц, сэдэв, гол санааг тодорхойлдог.
		Сурагч уншсан эхийн орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлдог.
		Сурагч уншсан эхээс жишээ, баримт, мэдээллийг нэгтгэж дүгнэдэг. /Уран зохиолын бус эх/
		Сурагч зохиогчийн илэрхийлсэн мэдрэмж, сэтгэлийн өнгө аясыг нь тайлбарладаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч уншсан эхийн бүтэц, сэдэв, гол санааг тодорхойлдог.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг олж, тус бүрд юуны тухай өгүүлснийг тодорхойлдог.	Эхийн сэдэв, гол санааг түлхүүр үгээр тодорхойлдог.	Эхийн сэдэв, гол санааг түлхүүр өгүүлбэрээр тодорхойлдог.	Эхийн бүтэц, сэдэв, агуулга, гол санааны уялдаа холбоог тодорхойлдог.
Сурагч уншсан эхийн орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлдог.	Эхэд үйл явдал ямар орчин /хэзээ, хаана/-д өрнөж буйг тодорхойлдог.	Эхэд өрнөсөн үйл явдлыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлэн тодорхойлдог.	Эхэд үйл явдал өрнөсөн орчны дүрслэлийг дүрийн үйлдэл, үг яриатай холбон тодорхойлдог.	Эхэд үйл явдал өрнөсөн орчны дүрслэлийг эхийн сэдэв, гол санаатай холбон тодорхойлдог.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Сурагч уншсан эхээс жишээ, баримт, мэдээллийг нэгтгэж дүгнэдэг. /Уран зохиолын бус эх/	Эхээс хэнд зориулж, хэн, хэзээ, яагаад бичсэн баримтыг олдог.	Эхэд ашигласан баримтуудыг бүлэглэж, тулгуур үг, оюуны зураглалаар харуулж дүгнэдэг.	Эхэд ашигласан жишээ, баримт эхэд ямар үүрэгтэйг тайлбарлаж дүгнэдэг.	Эхэд ашигласан жишээ баримт нь зохиогчийн илэрхийлсэн үзэл бодолтой яаж холбогдож байгааг дүгнэдэг.
Сурагч зохиогчийн илэрхийлсэн мэдрэмж, сэтгэлийн өнгө аясыг нь тайлбарладаг.	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн үг хэллэгийг олж тайлбарладаг.	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн зарим хэсгийг эхийн бүтэцтэй холбон тайлбарладаг.	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн зарим хэсгийг дүрийн үйл хөдлөл, үг яриатай холбон тайлбарладаг	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн үг хэллэгийг эхийн сэдэв, гол санаатай холбон тайлбарладаг

1.2.2. Үнэлгээний нэгж 2. Хүүрнэсэн эх зохиож бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
6.2а. Захидал, намтар, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээг орон, цагийн дарааллаар өрнүүлэн, учир шалтгааны уялдаа холбоотой бичих 6.2б. Үлгэр, өгүүллэг зохиохдоо орон, цагийн дарааллаар өрнүүлэн, сэдэв, агуулгыг учир шалтгааны уялдаа холбоотой бичих 6.2в. Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичих 6.2д. Хэлц ашиглан мэдрэмж, сэтгэгдлээ дүрслэн бичих 6.2ж. Үйл явдлыг хэн?, хаана?, юу? яагаад?, хэрхэн? яав? гэсэн асуултын дагуу мэдээлж бичих 6.2з. Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг илүүдсэн, давтсан зэрэг алдааг таньж, сайжруулах	Сурагч хүүрнэсэн эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болно. /захидал, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээ, үлгэр, өгүүллэг/

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хүүрнэсэн эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болно. /захидал, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээ, үлгэр, өгүүллэг/	Сурагч эхийн эхлэл, гол төгсгөл хэсгийг ялгаж бичдэг.
		Сурагч орон, цаг хугацааны дарааллаар уялдаа холбоотой бичдэг.
		Сурагч эхийг ойлгомжтой, утга санааг тодорхой бичдэг.
		Сурагч эхэд сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлж бичдэг.
		Сурагч найруулга, ЗБД-ийн алдаагүй бичдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч эхийн эхлэл, гол төгсгөл хэсгийг ялгаж бичдэг.	Эхлэл, гол, төгсгөлийг зааглаж ялгалгүй бичсэн.	Эхлэл, гол, төгсгөлийн аль нэгийг догол мөрөөр ялгалгүй бичсэн.	Эхлэл, гол, төгсгөлийг догол мөрөөр ялгасан боловч буруу ялгасан.	Эхлэл, гол, төгсгөл хэсгийг догол мөрөөр зөв ялгаж бичсэн
Сурагч орон, цаг хугацааны дарааллаар уялдаа холбоотой бичдэг.	Эхийн агуулга бүхэлдээ уялдаа холбоогүй.	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн боловч ихэнх хэсгийн уялдаа холбоо сул.	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн, зарим хэсгийн уялдаа холбоо сул.	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар өрнүүлсэн, уялдаа холбоо сайтай.
Сурагч эхийг ойлгомжтой, утга санааг тодорхой бичдэг.	Санаа нь тодорхойгүй, ойлгомж муутай.	Санаа нь тодорхой ч уншихад сонирхолгүй, жишээ баримт бараг ашиглаагүй.	Санаа нь тодорхой, ойлгомжтой, ашигласан зарим жишээ баримт тохироогүй.	Санаа нь тодорхой, ойлгомжтой, уншихад сонирхолтой, тохирсон жишээ баримт ашигласан.
Сурагч эхэд сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлж бичдэг.	Сэтгэгдэл мэдрэмжээ огт илэрхийлээгүй.	Сэтгэгдэл мэдрэмжээ ганц нэг үгээр илэрхийлсэн.	Сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлж, шалтгааныг нь бичсэн.	Сэтгэгдэл мэдрэмжээ маш тодорхой илэрхийлдэг.
Сурагч найруулга, ЗБД-ийн алдаагүй бичдэг.	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа ихтэй 6-аас дээш	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа 4-өөс дээш	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа 3 хүртэл	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн нэг ч алдаагүй.

1.2.3. Үнэлгээний нэгж 3. Хүүрнэсэн эхийг дэлгэрүүлэх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
6.2г. Эхэд өөрийн санаа, харилцан яриа оруулан дэлгэрүүлж бичих 6.2е. Товч мэдээллийг холбоотой баримтаар дэлгэрүүлэх	Сурагч өгсөн мэдээллийг баримт жишээ, өөрийн санаа, харилцан яриагаар дэлгэрүүлэн бичиж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өгсөн мэдээллийг баримт жишээ, өөрийн санаа, харилцан яриагаар дэлгэрүүлэн бичиж чаддаг болно.	Сурагч мэдээллийг жишээ баримт, өөрийн санаа, харилцан яриагаар дэлгэрүүлдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	VI
Сурагч мэдээллийг жишээ баримт, өөрийн санаа, харилцан яриагаар дэлгэрүүлдэг.	Өгсөн мэдээлэл /хэн?, юуг?, яав?/-ийг хаана, хэзээ болсныг баримтаар дэлгэрүүлдэг.	Өгсөн мэдээллийг тохирсон жишээ баримтаар дэлгэрүүлдэг.	Өгсөн мэдээллийн санааг дэмжсэн харилцан яриа оруулан дэлгэрүүлдэг.	Өгсөн мэдээллийн гол санааг баталж чадах жишээ баримт, өөрийн санаа, харилцан яриаг оруулан дэлгэрүүлдэг.

1.2.4. Үнэлгээний нэгж 4. Харилцан ярих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
6.3а. Тодорхой сэдвээр ярилцахдаа гол асуудлыг ойлгон, асуулт асууж тодруулах 6.3б. Санаа бодлоо бусдынхтай холбож, харилцан ярих	Сурагч тодорхой асуудлаар бусдыг ойлгон харилцаж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч тодорхой асуудлаар бусдыг ойлгон харилцаж чаддаг болно.	Сурагч бусадтай харилцахдаа асуулт асууж, санаа бодлыг нь ойлгон харилцдаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	VI
Сурагч бусадтай харилцахдаа асуулт асууж, санаа бодлыг нь ойлгон харилцдаг.	Бусдын санааг дутмаг ойлгож харилцдаг.	Гол ба гол бус асуудлыг хольж, цөөн үгээр харилцдаг.	Гол асуудлыг ойлгон, асуулт асууж лавшруулан харилцдаг.	Гол санааг ойлгож, өөрийн санаа бодолтой холбож харилцдаг.

1.2.5. Үнэлгээний нэгж 5. Хэл зүйн шинж, хэрэглээ

Суралцахуйн зорилтын код, өгүүлбэр	Суралцахуйн үр дүн
6.1и. Уншсан эхэд жинхэнэ нэр, нэрийн тийн ялгал, биед ба эзэнд хамаатуулах нөхцөл, олон тооны дагаврыг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох 6.1к. Уншсан эхэд үйлийн цагаар төгсгөх болон биеэр төгсгөх, тодотгон холбох болон нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох 6.1л. Уншсан эхэд орон цагийн нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох	Сурагч уншсан эхээс жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэрийг олж, хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг болсон байна.
6.1м. Өгүүлбэрийг гишүүдээр хурааж, дэлгэрүүлэх 6.1к. Уншсан эхэд үйлийн цагаар төгсгөх болон биеэр төгсгөх, тодотгон холбох болон нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох	Сурагч өгүүлбэрийн цөм ба цөм бус бүтцийг ялгаж чаддаг болсон байна.
6.2и. Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих	Сурагч бүтээврийн нийлцийг бичихдээ зөв бичих дүрмийн мэдлэгээ хэрэглэж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч уншсан эхээс жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэрийг олж, хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг болсон байна.	Сурагч эх, өгүүлбэрт байгаа жинхэнэ нэрийг олж, утга, бүтцээр задалж, бүтээврүүдийг тодорхойлдог.
		Сурагч эх, өгүүлбэрт байгаа үйл үгийг утга, бүтцээр нь задалж, бүтээврүүдийг тодорхойлдог.
		Сурагч эх, өгүүлбэрт байгаа орон цагийн нэрийг утга, бүтцээр нь задалж тодорхойлдог.
2	Сурагч өгүүлбэрийн цөм ба цөм бус бүтцийг ялгаж чаддаг болсон байна.	Сурагч өгүүлбэрийг гишүүдээр дэлгэрүүлж, хураадаг.
3	Сурагч бүтээврийн нийлцийг бичихдээ зөв бичих дүрмийн мэдлэгээ хэрэглэж чаддаг болсон байна.	Сурагч бүтээврийн нийлцийг зөв бичдэг. /гээгдэх, гээгдэхгүй эгшиг; зөөлний тэмдэг “и” болох, болохгүй/

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	VI
Сурагч эх, өгүүлбэрт байгаа жинхэнэ нэрийг олж, утга, бүтцээр задалж, бүтээврүүдийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс жинхэнэ нэрийг асуултаар олж, утга /ерийн ба оноосон нэр/-ыг тодорхойлдог.	Сонгосон жинхэнэ нэрийг бүтцээр задалж, бүтээврийг язгуур, НҮБД, тоо, тийн ялгал, хамаатуулах нөхцөлийг тодорхойлдог.	Сонгосон жинхэнэ нэр нь тухайн өгүүлбэр, эхэд ямар үүрэгтэй байгааг тодорхойлдог.	Танил биш эхээс сонгосон жинхэнэ нэрийг тухайн эхэд ямар утга, үүргээр хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлдог.
Сурагч эх, өгүүлбэрт байгаа үйл үгийг утга, бүтцээр нь задалж, бүтээврүүдийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс үйл үгийг асуултаар олж, утга /тусгах ба эс тусгах/-ыг тодорхойлдог.	Сонгосон үйл үгийг утга, бүтэц /язгуур, ҮҮБД, хэв, байдал, үйлийн холбох (тодотгон, нөхцөлдүүлэн) ба төгсгөх (биеэр, цагаар) нөхцөл/-өөр задалж, бүтээврүүдийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс сонгосон үйл үгийн бүтэц, тухайн эхэд ямар утга, үүргээр хэрэглэснийг тодорхойлдог.	Танил биш эхээс сонгосон үйл үгийг тухайн эхэд ямар утга, үүргээр хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлдог.
Сурагч эх, өгүүлбэрт байгаа орон цагийн нэрийг утга, бүтцээр нь задалж тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс орон цагийн нэрийг асуултаар олж утга /орон ба цаг/-ыг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс сонгосон орон цагийн нэрийг утга, бүтэц /тийн ялгал, хамаатуулах нөхцөл/-ээр задалж, бүтээврүүдийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс сонгосон орон цагийн нэрийн бүтэц, тухайн эхэд ямар утга, үүргээр хэрэглэснийг тодорхойлдог.	Танил биш эхээс сонгосон орон цагийн нэрийн бүтэц, тухайн эхэд ямар утга, үүргээр хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлдог.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Сурагч өгүүлбэрийг гишүүдээр дэлгэрүүлж, хураадаг.	Дэлгэрэнгүй / цөм бус/ өгүүлбэрийг хэн/ юу?, хэнийг/ юуг, яав? ...?, асуултаар цөм бүтцэд хураадаг.	Дэлгэрэнгүй /цөм бус/ өгүүлбэрийг гол гишүүдээр ялган хураадаг.	Цөм өгүүлбэрийг орон ба цагийн утгаар нэмэн дэлгэрүүлдэг	Цөм өгүүлбэрийг орон ба цаг, зорилго, шалтгааны утгаар нэмэн дэлгэрүүлдэг
Сурагч бүтээврийн нийлцийг зөв бичдэг. /гээгдэх, гээгдэхгүй эгшиг; зөөлний тэмдэг “и” болох, болохгүй/	Өргөн хэрэглэгддэг үгийг ихэнх тохиолдолд бүтээврийн нийлцийг алдаатай бичдэг.	Өргөн хэрэглэгддэг үгийг ихэнх тохиолдолд бүтээврийн нийлцийг алдаагүй бичдэг.	Өргөн хэрэглэгддэг үгийг бүтээврийн нийлцийн алдаа багатай бичдэг.	Ямар ч тохиолдолд бүтээврийн нийлцийг алдаагүй бичдэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ

2.1. VII АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч тоочин дүрсэлсэн эхийг үндсэн шинжээр нь ялган таньж тодорхойлдог, задлан шинжилдэг, сонин содон үг хэллэг, мэдрэмж сэтгэгдлээ оруулан гадаад, дотоод шинжийг дүрслэн бичиж, батлах нотлох, үгүйсгэх, дэмжих байдлаар үзэл бодлоо илэрхийлэх чадвар эзэмшинэ.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

2.2.1. Үнэлгээний нэгж 1. Тоочсон эхийг уншиж ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.1а. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал зэрэг хүн, юм, үзэгдлийн гадаад дотоод шинж, үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж үндсэн шинжийг ялган таних	Сурагч тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинжийг ялган таньж бүтэц, агуулгын уялдаа холбоог тодорхойлж чаддаг болсон байна.
7.1б. Товч танилцуулга, илтгэх хуудас зэрэг тоочсон эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних	Сурагч тоочин дүрсэлсэн эхээс сонин содон үг хэллэг, уран дүрслэл, хэлцийн утга, үүргийг тодорхойлж, чаддаг болсон байна.
7.1г. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал зэрэг эхээс содон сонин үг хэллэг, уран дүрслэл (адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал), хэлцийн утга, үүргийг тодруулж, тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таних	Сурагч тоочин дүрсэлсэн эхийн сэдэв, гол санааг тодорхойлж чаддаг болсон байна.
7.1в. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал, товч танилцуулга, илтгэх хуудас зэрэг эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох	Сурагч тоочин дүрсэлсэн эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах
7.1б. Товч танилцуулга, илтгэх хуудас зэрэг тоочсон эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних	Сурагч тоочин дүрсэлсэн эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах
7.1д. Эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах	Сурагч тоочин дүрсэлсэн эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинжийг ялган таньж бүтэц, агуулгын уялдаа холбоог тодорхойлж чаддаг болсон байна.	Сурагч тоочсон эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилдэг.
2	Сурагч тоочин дүрсэлсэн эхээс сонин содон үг хэллэг, уран дүрслэл, хэлцийн утга, үүргийг тодорхойлж, чаддаг болсон байна.	Сурагч сонин содон үг хэллэг, уран дүрслэл, хэлцийн үүргийг тодруулж тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таньдаг.
3	Сурагч тоочин дүрсэлсэн эхийн сэдэв, гол санааг тодорхойлж чаддаг болсон байна.	Сурагч загварт найруулгаар тоочин бичсэн эхийг задлан шинжлэхдээ зориулалт, гол санаа, баримт нотолгоог ялгаж чадна.
4	Сурагч тоочин дүрсэлсэн эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах чаддаг болно.	Сурагч тоочин дүрсэлсэн эхээс бичлэгийн төрөл, онцлогийг илэрхийлэхэд чухал нөлөөтэй хэсгийг /яагаад чухал гэж үзсэн үндэслэлээ/ тайлбарладаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч тоочсон эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилдэг.	Эхийн бүтцийг ялгаж чаддаг.	Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжлэхдээ тоочсон өгүүлбэрийг ялгаж чаддаг.	Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжлэхдээ юм үзэгдлийн гадаад, дотоод шинжийг тоочиж чаддаг.	Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж тоочсон эхийн үндсэн шинжийг ялган таньж чаддаг.
Сурагч сонин содон үг хэллэг, уран дүрслэл, хэлцийн үүргийг тодруулж тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таньдаг.	Сонин содон үг хэллэгийг ялган таньдаг.	Сонин содон үг хэллэг, адилтгал, амьдчилалыг ялган таньдаг.	Уран дүрслэл, хэлцийн үүргийг шинжилж ялган таньдаг.	Сонин содон үг хэллэг, уран дүрслэл, хэлцийн үүргийг шинжилж ялган таньдаг.
Сурагч загварт найруулгаар тоочин бичсэн эхийг задлан шинжлэхдээ зориулалт, гол санаа, баримт нотолгоог ялгаж чадна.	Загварт найруулгаар тоочин бичсэн эхийг таньдаг.	Загварт найруулгаар тоочин бичсэн эхийг таньж уншаад гол санааг тодорхойлдог.	Загварт найруулгаар тоочин бичсэн эхийг уншаад зориулалт, гол санааг тодорхойлдог.	Загварт найруулгаар тоочин бичсэн эхийг задлан шинжлэхдээ зориулалт, гол санаа, баримт нотолгоог тодорхойлдог.
Сурагч тоочин дүрсэлсэн эхээс бичлэгийн төрөл, онцлогийг илэрхийлэхэд чухал нөлөөтэй хэсгийг / яагаад чухал гэж үзсэн үндэслэлээ/ тайлбарладаг.	Эхийн гол санааг тодруулахад чухал үүрэгтэй цөөн хэдэн үгийг тайлбарладаг.	Эхийн гол санааг тодруулахад чухал үүрэгтэй үг, хэллэгүүдийг тайлбарладаг.	Эхийн гол санааг тодруулахад чухал үүрэгтэй үг хэллэг, өгүүлбэрүүдийг тайлбарладаг.	Эхийн гол санааг илэрхийлэхэд чухал үүрэгтэй хэсгүүдээр зохиогчийн зорилгыг илтгэн яагаад чухал гэж үзсэн үндэслэлээ тайлбарладаг.

2.2.2. Үнэлгээний нэгж 2. Тоочин дүрсэлсэн эх зохиож бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.2а. Сонин содон үг хэллэг, тэмдэг нэр, мэдрэмж сэтгэгдэл оруулан, гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж хөрөг бичих 7.2б. Хэлц, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг ашиглан үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлж аян замын тэмдэглэл бичих	Сурагч тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болсон байна.
7.2в. Тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашиглан танилцуулга, илтгэх хуудсыг тоочин бичих	Сурагч тогтсон бүтэц, загварын дагуу албан бичгийн эх зохиож чаддаг болсон байна.
7.2г. Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг буруу хэлбэржүүлсэн, оновчгүй сонгосон зэрэг алдааг таньж, сайжруулах	Сурагч эхийн найруулгын алдааг засан сайжруулж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч тоочин дүрсэлсэн эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болсон байна.	Сурагч тоочин дүрсэлсэн эх бичихдээ сонин содон үг хэллэг, хэлц, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг ашигладаг.
3	Сурагч тогтсон бүтэц, загварын дагуу албан бичгийн эх зохиож чаддаг болсон байна.	Сурагч загварын дагуу эх /танилцуулга, илтгэх хуудас/ зохиохдоо тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашигладаг.
4	Сурагч эхийн найруулгын алдааг засан сайжруулж чаддаг болсон байна.	Сурагч эхээс үг буруу хэлбэржүүлсэн, оновчгүй сонгосон алдааг олж засдаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч тоочин дүрсэлсэн эх бичихдээ сонин содон үг хэллэг, хэлц, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг ашигладаг.	Гадаад, дотоод шинжийг илэрхийлэхдээ хэлц ашиглалгүй өөрийн үгээр бичдэг.	Гадаад, дотоод шинжийг илэрхийлэхдээ эхийн аль нэг үйл явдалд тохирсон хэлцийг сонгон бичдэг.	Гадаад, дотоод шинжийг илэрхийлэхдээ хэлц, уран дүрслэл оруулан бичдэг.	Гадаад, дотоод шинжийг илэрхийлэхдээ хэлц, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг ашиглан үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлж бичдэг.
Сурагч загварын дагуу эх /танилцуулга, илтгэх хуудас/ зохиохдоо тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашигладаг.	Өгсөн загварын дагуу тооны нэр ашиглан бичдэг.	Загварыг ашиглан бичдэг.	Загварын дагуу жишээ ашиглан тоочин бичдэг.	Загварт найруулгаар бичихдээ баримт нотолгоо, жишээ ашиглан тоочин бичдэг.
Сурагч эхээс үг буруу хэлбэржүүлсэн, оновчгүй сонгосон алдааг олж засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн, давтсан алдааг буруу олж засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн, давтсан зарим алдааг олж засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн, давтсан ихэнх алдааг олж засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн, давтсан алдааг бүрэн олж засдаг.

2.2.3. Үнэлгээний нэгж 3. Зөв бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.2д. Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих	Сурагч бүтээврийн нийлцийг бичихдээ зөв бичих дүрмийн мэдлэгээ хэрэглэж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч бүтээврийн нийлцийг бичихдээ зөв бичих дүрмийн мэдлэгээ хэрэглэж чаддаг болсон байна.	Сурагч бичихдээ бүтээврийн нийлц дэх өөрчлөлт, тусгай дүрмийг зөв бичдэг. /гээгдэх, гээгдэхгүй; зөөлний тэмдгийн үүрэг, авиа ондооших/

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч бичихдээ бүтээврийн нийлц дэх өөрчлөлт, тусгай дүрмийг зөв бичдэг. /гээгдэх, гээгдэхгүй; зөөлний тэмдгийн үүрэг, авиа ондооших/	Бүтээврийн нийлцийг ихэнхдээ алдаатай бичдэг.	Танил үгсийн бүтээврийн нийлцийг зарим тохиолдолд алдаагүй бичдэг.	Танил биш үгсийн бүтээврийн нийлцийг ихэнх тохиолдолд алдаагүй бичдэг.	Бүтээврийн нийлц дэх өөрчлөлт, тусгай дүрмүүдийг бүх тохиолдолд зөв, алдаагүй бичдэг.

2.2.4. Үнэлгээний нэгж 4. Хэлзүй

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.1е. Эхэд тооны нэр, тэмдэг нэр, дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын утга, үүргийг тодорхойлох 7.1ж. Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг эхийн жишээгээр тодруулан, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлах 7.1з. Эхэд эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарлаж, найруулгын утга, үүргийг тодорхойлох	Сурагч уншсан эхэд тооны нэр, тэмдэг нэр, дуурайх үг, зэрэгцсэн нийлмэл үг, ЗНӨ-ийн хэл зүйн шинж, утга, найруулгын үүргийг тодорхойлж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч уншсан эхэд тооны нэр, тэмдэг нэр, дуурайх үг, зэрэгцсэн нийлмэл үг, ЗНӨ-ийн хэл зүйн шинж, утга, найруулгын үүргийг тодорхойлж чаддаг болсон байна.	Сурагч эх, өгүүлбэрээс тооны нэрийг олж бүтээврүүдийг тодорхойлдог.
		Сурагч эх, өгүүлбэрээс тэмдэг нэрийг олж, бүтээврүүдийг тодорхойлдог.
		Сурагч үйлийг тоочин дүрслэхдээ дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг.
		Сурагч хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг тодруулан, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлаж чаддаг.
		Сурагч ойролцоо ба эсрэг утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарладаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч эх, өгүүлбэрээс тооны нэрийг олж бүтээврүүдийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэр дэх тооны нэрийг асуултаар олж, утгыг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрт тооны нэрийн гүйцэтгэсэн үүргийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс сонгосон тооны нэрийг тухайн эхэд ямар утга, үүргээр хэрэглэснийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрт тооны нэр хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын утга үүргийг тодорхойлж чаддаг.
Сурагч эх, өгүүлбэрээс тэмдэг нэрийг олж, бүтээврүүдийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэр дэх тэмдэг нэрийг асуултаар олж, утгыг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрт тэмдэг нэрийн гүйцэтгэсэн үүргийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрээс сонгосон тэмдэг нэрийг тухайн эхэд ямар утга, үүргээр хэрэглэснийг тодорхойлдог.	Уншсан эх, өгүүлбэрт тэмдэг нэр хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын утга үүргийг тодорхойлж чаддаг.
Сурагч үйлийг тоочин дүрслэхдээ дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг.	Үйлийг тоочин дүрслэхдээ дуурайх үгийг зааврын дагуу ашигладаг.	Үйлийг тоочин дүрслэхдээ хялбар нөхцөлд дуурайх үгийг ашигладаг.	Үйлийг тоочин дүрслэхдээ дуурайх үгийг оновчтой ашигладаг.	Үйлийг тоочин дүрслэхдээ дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, оновчтой ашигладаг.
Сурагч хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг тодруулан, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлаж чаддаг.	Үг, өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбосон 3 аргыг ялгаж тайлбарлаж чаддаг.	Зэрэгцүүлэн холбох үг зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг жишээгээр тодруулан тайлбарлаж чаддаг.	Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг жишээгээр тодруулан тайлбарлаж чаддаг.	Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг эхийн жишээгээр тодруулан, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлаж чаддаг.
Сурагч ойролцоо ба эсрэг утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарладаг.	Ойролцоо ба эсрэг утгатай үгийг сонгосон учрыг тайлбарлах гэж оролддог.	Ойролцоо ба эсрэг утгатай үгийг сонгосон учрыг тайлбарладаг.	Ойролцоо ба эсрэг утгатай зарим зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарладаг.	Ойролцоо ба эсрэг утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарладаг.

2.2.5. Үнэлгээний нэгж 5. Харилцан ярих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
Сургууль, анги хамт олны өмнө тулгамдсан асуудлаас сонгон, баримт мэдээллийг судалж, чухлыг сонгон, санаа бодлоо илэрхийлж ярих Тулгамдсан асуудлын хүрээнд хэлэлцүүлэг хийхдээ баталж нотолж, дэмжиж, үгүйсгэж ярих	Сурагч хамт олны өмнө санаа бодлоо илэрхийлэхдээ асуудлыг баримтаар нотолж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хамт олны өмнө санаа бодлоо илэрхийлэхдээ асуудлыг баримтаар нотолж чаддаг болсон байна.	Сурагч асуудлаас чухлыг сонгон өөрийн санаа бодлыг илэрхийлэхдээ батлах баримт нотолгоог /баталж нотолж, дэмжиж, үгүйсгэж/ хэрэглэдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч асуудлаас чухлыг сонгон өөрийн санаа бодлыг илэрхийлэхдээ батлах баримт нотолгоог / баталж нотолж, дэмжиж, үгүйсгэж/ хэрэглэдэг.	Сургууль хамт олны өмнө тулгамдсан асуудлаар санаа бодлоо илэрхийлж ярихыг хүсдэг.	Сургууль хамт олны өмнө тулгамдсан асуудлаар ихэнхдээ санаа бодлоо илэрхийлж ярьдаг.	Сургууль хамт олны өмнө тулгамдсан асуудлаар санаа бодлоо илэрхийлж ярьдаг.	Сургууль хамт олны өмнө тулгамдсан асуудлаар санаа бодлоо баталж нотолж / дэмжиж, үгүйсгэж/ илэрхийлж ярьдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

3.1. VIII АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч тоочин тайлбарласан эхийн үндсэн шинжийг ялган таньдаг, задлан шинжилдэг, хэлц, уран дүрслэл, ашиглан үзэл бодлоо илэрхийлэн бичихдээ жишээ баримт ашиглан тогтвортой хөгжлийн хүрээнд баталж нотолж үгүйсгэж ярих чадвар эзэмшинэ.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

3.2.1. Үнэлгээний нэгж 1. Тоочсон эхийг уншиж ойлгох

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
8.1.а Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр тоочин тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних	Сурагч тоочин тайлбарласан эхийг задлан шинжилж, үндсэн шинжээр нь ялган таньдаг болно / шинжлэх ухаан, танин мэдэхүйн богино эх, өргөдөл, хүсэлт, заавар/
8.1.б. Учир шалтгааныг тайлбарласан, дүрслэн тайлбарласан, тоочин тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тайлбарлах	
8.1.в Эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган, учрыг тайлбарлах	
8.1.г Өргөдөл, хүсэлт, заавар зөвлөгөө зэрэг албан бичгийн эхийн бүтэц, үгийн санг задлан шинжилж, найруулгын онцлогийг тодорхойлох	
8.1.д Эхээс баримт мэдээллийг ялгаж, бүтэц дараалалтай холбон дүгнэх	
8.1.ж Уншсан эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж дүгнэлт гаргах	
8.1.е Уншсан эхэд дэвшүүлсэн асуудал, шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж загварчлах	

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч тоочин тайлбарласан эхийг задлан шинжилж, үндсэн шинжээр нь ялган таньдаг болно /шинжлэх ухаан, танин мэдэхүйн богино эх, өргөдөл, хүсэлт, заавар/	Сурагч тоочин тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог нь ялган таньдаг.
		Сурагч тайлбарласан эхийн бүтэц, сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлдог.
		Сурагч эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялган, учрыг тайлбарлаж чаддаг.
		Сурагч албан бичгийн эхийн бүтэц, үгийн сан, хэл найруулгыг тодорхойлдог
		Сурагч эхээс баримт мэдээллийг ялгаж дүгнэлт гаргаж чаддаг.
		Сурагч эхэд дэвшүүлсэн асуудал, тэдгээрийн шалтгаан үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлон загварчилдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч тоочин тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог нь ялган таньдаг.	Тоочин тайлбарласан эхийн бүтцийг ялгаж таньдаг. /эхлэл, гол, төгсгөл хэсэг, ерөнхий ба дэд сэдэв, түлхүүр үг, цогцолбороор хэсэглэх/	Эхийн холбоос тоочин тайлбарласан эхийн агуулгатай хэрхэн уялдаж байгааг, эхэд уран дүрслэл, үнэлэлт дүгнэлт өгсөн хэсэг, шүүмж, эргэцүүлэл, баримт, тайлбар зэрэг байгаа эсэхийг ялган таньдаг.	Тоочин тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжлэхдээ ямар ямар арга болон баримт ашигласныг ялган таньдаг.	Тоочин тайлбарласан эхэд уран дүрслэл ийн ямар арга хэрэглэснийг ялган таньдаг.
Сурагч тайлбарласан эхийн бүтэц, сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлдог.	Тайлбарласан эхийн сэдвийг илэрхийлсэн түлхүүр үгийг ялган тодорхойлдог.	Тайлбарласан эхийн сэдвээс үүдэн зохиогчийн гол санааг ялган тодорхойлдог.	Тайлбарласан эхийн цогцолбор хоорондын холбоосыг тодруулж, эхэд ашигласан хэлц, уран дүрслэлийг ялган тодорхойлдог.	Тайлбарласан эхийн хэсгүүдийн уялдаа холбоо, баримт дүрслэл, тэдгээрийн үүргийг ялган тодорхойлдог.
Сурагч эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялган, учрыг тайлбарлаж чаддаг.	Эхээс зохиогчийн мэдрэмжийг ялган уншдаг.	Эхээс зохиогчийн сэтгэгдлийг ялган уншдаг.	Эхээс зохиогчийн ялгаатай мэдрэмж, сэтгэгдлийг ялган уншдаг.	Эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн үгсийн утгыг тайлбарладаг.
Сурагч албан бичгийн эхийн бүтэц, үгийн сан, хэл найруулгыг тодорхойлдог	Өргөдөл, хүсэлт, заавар зөвлөгөөг уншихдаа гол санааг нь ойлгож уншдаг.	Хэнд хандаж бичсэн болоод юу хүсэж байгаа учир шалтгааныг нь бодож уншдаг.	Өргөдөл, хүсэлт, заавар зөвлөгөөний бүтэц, агуулга, найруулгыг судалж уншдаг.	Өргөдөл, хүсэлт, заавар зөвлөгөөнд хэрэглэсэн үг хэллэгийг ажиглаж, дүгнэлт гарган уншдаг.
Сурагч эхээс баримт мэдээллийг ялгаж дүгнэлт гаргаж чаддаг.	Тоочин тайлбарласан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялган уншдаг.	Эхийн сэдэв, дэд сэдэв, дүгнэлт хэсгийн уялдаа холбоог тодорхойлдог.	Эхийн зохиогчийн зорилгыг тодорхойлохдоо тоочин тайлбарлаж бичих онцлогийг илрүүлдэг.	Эхийн үгийн утгыг шинжлэн, өгүүлбэр, цогцолборуудын холбоос дарааллыг тодорхойлж, эхийн баримтад шинжилгээ хийн дүгнэлт гаргадаг.
Сурагч эхэд дэвшүүлсэн асуудал, тэдгээрийн шалтгаан үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлон загварчилдаг.	Эхийн цогцолбор бүрийн утга санааг тодорхойлж уншдаг.	Эхийн агуулгыг шинжлэн, гол санааг дүгнэж уншдаг.	Эхийн агуулгыг шинжлэн, гол санааг дүгнэж ярилцахдаа, янз бүрийн асуудлын уялдаа холбоог тодорхойлж, баримтыг харьцуулж уншдаг.	Эхийн агуулгыг шинжлэн, гол санааг дүгнэж ярилцахдаа, янз бүрийн асуудлын уялдаа холбоог тодорхойлж, баримтыг харьцуулж ярихдаа шалтгаан үрийг харьцуулан уншдаг.

3.2.2. Үнэлгээний нэгж 2. ТАЙЛБАРЛАСАН ЭХ ЗОХИОН БИЧИХ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
8.2.а Жишээ баримтаар баталж, уялдаа холбоотой тоочин тайлбарлаж бичих 8.2.б, Хэлц, уран дүрслэл ашиглан, мэдрэмж сэтгэгдэл, үзэл бодлоо тусган найруулж бичих 8.2.г Угсруулан холбох үг, нөхцөлүүдийг ашиглан учир шалтгааныг тайлбарласан эх зохиож бичих 8.2.д Жишээ баримт ашиглан дүрслэн тайлбарласан эх зохиож бичих 8.2.в Өргөдөл, зөвлөгөөг албан бичгийн тогтсон бүтэц, загварын дагуу учир шалтгааны холбоо хамааралтай бичих 8.2.е Өөрийн болон бусдын зохиосон эхийг хянан шинжилж, найруулгыг засан сайжруулах 8.2.ж Зохион найруулсан эхээс баримтын учир зүйн холбох үгийг буруу хэрэглэсэн алдааг таньж, найруулгыг сайжруулах	Сурагч тайлбарласан эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болсон байна. /өргөдөл, зөвлөгөө/

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
2	Сурагч тайлбарласан эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болсон байна. /өргөдөл, зөвлөгөө/	Сурагч эх зохиохдоо мэдрэмж сэтгэгдэл, үзэл бодлоо тусган тайлбарлаж бичих
		Сурагч өргөдөл, зөвлөгөөг тогтсон бүтцээр учир шалтгааны холбоо хамааралтай бичдэг.
		Сурагч зохиосон эхийн баримтын болон учир зүйн алдаа болон холбох үгийг буруу хэрэглэсэн алдааг олж засдаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч эх зохиохдоо мэдрэмж сэтгэгдэл, үзэл бодлоо тусган тайлбарлаж бичих	Тайлбарласан эх зохион бичихдээ хэлц ашиглан бичдэг.	Тайлбарласан эх зохион бичихдээ хэлц, уран дүрслэл ашиглан бичдэг.	Тайлбарласан эх зохион бичихдээ хэлц, уран дүрслэл ашиглан мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо тусган бичдэг.	Тайлбарласан эх зохион бичихдээ хэлц, уран дүрслэл, жишээ баримт ашиглан мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо тусган бичдэг.
Сурагч өргөдөл, зөвлөгөөг тогтсон бүтцээр учир шалтгааны холбоо хамааралтай бичдэг.	Өргөдөл, зөвлөгөөг тогтсон загварын дагуу бичдэг.	Загварыг ашиглан бичдэг.	Загварын дагуу жишээ ашиглан тоочин бичдэг.	Загварт найруулгаар бичихдээ учир шалтгааны холбоо хамааралтай бичдэг.
Сурагч зохиосон эхийн баримтын болон учир зүйн алдаа болон холбох үгийг буруу хэрэглэсэн алдааг олж засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн алдааг засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн, давтсан зарим алдааг олж засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн, давтсан ихэнх алдааг олж засдаг.	Эхийн найруулгын алдааг шалгаж, үг илүүдсэн, давтсан алдааг бүрэн олж засдаг.

3.2.3. Үнэлгээний нэгж 3. Харилцан ярих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
8.3.а Сонсогчоо мэдэрч, оновчтой баримт, мэдээлэл ашиглан илтгэх 8.3.б Тогтвортой хөгжлийн сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлэн баталж, нотолж, тайлбарлаж ярих	Сурагч тодорхой асуудлын хүрээнд санаа бодлоо ойлгомжтой илэрхийлж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
3	Сурагч тодорхой асуудлын хүрээнд санаа бодлоо ойлгомжтой илэрхийлж чаддаг болсон байна.	Сурагч асуудлаас чухлыг сонгон өөрийн санаа бодлыг илэрхийлэхдээ баримт мэдээлэл ашиглан /баталж нотолж/ тайлбарлан ярьж чадна.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч асуудлаас чухлыг сонгон өөрийн санаа бодлыг илэрхийлэхдээ баримт мэдээлэл ашиглан / баталж нотолж/ тайлбарлан ярьж чадна.	Өөрийн цуглуулсан мэдээллээр товч ярьдаг.	Бусдын яриаг анхааралтай сонсож, чухал гэсэн хэсгээ тэмдэглэдэг.	Тэмдэглэсэн чухал хэсгээ дэлгэрүүлэн ярихдаа харсан, сонссон, уншсан зүйлээсээ баримт мэдээлэл татан үзэл бодлоо шингээн ярьдаг.	Тэмдэглэсэн чухал хэсгээ дэлгэрүүлэн ярихдаа харсан, сонссон, уншсан зүйлээсээ баримт мэдээлэл татан үзэл бодлоо шингээн, бусдын чухал гэж сонгосон хэсэг өөрийнхтэй таарч байгаа эсэхийг тулгаж, ялгаатай санааг харьцуулан дүгнэж ярьдаг.

3.2.4. Үнэлгээний нэгж 4. Хэлний хэрэглээ

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
8.1.к Угсарсан нийлмэл үгийг ялган таньж, эх өгүүлбэрт гүйцэтгэсэн найруулгын үүргийг тодорхойлох 8.1.з Шалтгааны утгатай УНӨ-ийн бүтсэн аргыг тодорхойлох 8.2.г Угсруулан холбох үг, нөхцөлүүдийг ашиглан учир шалтгааныг тайлбарласан эх зохиож бичих 8.1.и Нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэгийн найруулгын үүргийг тодорхойлох	Сурагч уншсан эхээс угсарсан нийлмэл үг, нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэгийг таньж, хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
4	Сурагч уншсан эхээс угсарсан нийлмэл үг, нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэгийг таньж, хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг болсон байна.	Сурагч угсарсан нийлмэл үг, УНӨ-ийн бүтсэн аргыг задлан шинжилж, эх, өгүүлбэрт гүйцэтгэсэн үүргийг тайлбарладаг.
		Сурагч үг, нөхцөлийг ашиглан тайлбарласан эх зохиож чаддаг.
		Сурагч гадаад үг хэллэг, нутгийн аялгууны үгийн утга, эхэд гүйцэтгэсэн үүргийг эхийн хам бүтцийн хүрээнд тайлбарладаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч угсарсан нийлмэл үг, УНӨ-ийн бүтсэн аргыг задлан шинжилж, эх, өгүүлбэрт гүйцэтгэсэн үүргийг тайлбарладаг.	Уншсан эхээс нийлмэл үгийг асуултын тусламжтайгаар олдог.	Нийлмэл үгсийн бүрэлдэхүүнд байгаа үгсийн үүргийг ажиглах, бүлэглэх, бүтсэн аргыг ажиглан тайлбарладаг	Угсарсан нийлмэл үгийг тодорхойлдог.	Нийлмэл үгсийг өгүүлбэрт ямар утга үүрэгтэйг тодорхойлдог, шууд ба шууд бус утгаар ялгадаг
	Хоёр ба түүнээс дээш нийлмэл өгүүлбэрийг утгаар задлан тайлбарладаг.	Шалтгааны утгат холбоос хэрэглүүрийн үүргийг тодорхойлдог.	Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгож чаддаг.	Холбоосуудын утга үүргийг тодорхойлдог ба уран сайхны найруулга бүхий өгүүлбэрийг жишээг задлан тайлбарладаг.
Сурагч үг, нөхцөлийг ашиглан тайлбарласан эх зохиож чаддаг.	Угсруулан холбох үг ашиглан тайлбарласан эх зохион бичдэг.	Угсруулан холбох үг, нөхцөлийг ашиглан тайлбарласан эх зохион бичдэг.	Угсруулан холбох үг, нөхцөл, хэлцийг ашиглан тайлбарласан эх зохион бичдэг.	Угсруулан холбох үг, нөхцөлийг ашиглан мэдрэмж, үзэл бодлоо шингээн учир шалтгааныг тайлбарласан эх зохион бичдэг.
Сурагч гадаад үг хэллэг, нутгийн аялгууны үгийн утга, эхэд гүйцэтгэсэн үүргийг эхийн хам бүтцийн хүрээнд тайлбарладаг..	Нутгийн аялгууны үг болон гадаад үгийг таньдаг.	Нутгийн аялгууны үг болон гадаад үгийг ямар утгатай болохыг тайлбарладаг.	Нутгийн аялгууны үг болон гадаад үг нь эхэд ямар үүрэг гүйцэтгэж байгааг тайлбарладаг.	Нутгийн аялгууны үгсийн ижил тал болон хэл аялгууны харьцааг тодорхойлдог ба гадаад үгсийг монгол хэл рүү хөрвүүлбэл юу гэж нэрлэх талаар саналаа дэвшүүлдэг. Олон улсад тогтсон нэр томъёо нэршлийг гадаад үгээр тэмдэглэдэг гэдгийг мэддэг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IX АНГИ

4.1. IX АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Сурагч нь асуудал дэвшүүлэн, таамаглаж тайлбарласан эхийн үндсэн шинжийг ялган таньж, онцлогийг нь тодорхойлж, эхийн үгийн санг харьцуулан задлан шинжилдэг, найруулгын алдаагүй, цэг цэглэлийн дүрмийг баримтлан, үзэлбодлоо илэрхийлэн бичих чадвар эзэмшинэ.

4.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

4.2.1. Үнэлгээний нэгж 1. Тайлбарласан эхийн үндсэн шинжийг ялган таньж, тодруулах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.1а: Уншигчийн захидал, шүүмж зэрэг асуудал дэвшүүлэн тайлбарласан, учир шалтгааныг тайлбарласан, таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхийн бүтэц агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних 9.1г: Тайлбарласан эхийн агуулгыг баримт-үзэл бодол, шалтгаан-үр дагавар, таамаглал-баталгаа нотолгооны холбоо хамаарлаар ялган тодруулах	Сурагч тайлбарласан эхийн агуулга, бүтцийн уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таньж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч тайлбарласан эхийн агуулга, бүтцийн уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таньж чаддаг болсон байна.	Сурагч эхийн үндсэн шинжийг бүтэц ба баримт-үзэл бодол, шалтгаан үр дагавар, таамаглал- баримт нотолгоогоор ялган таньдаг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч эхийн үндсэн шинжийг бүтэц ба баримт-үзэл бодол, шалтгаан үр дагавар, таамаглал- баримт нотолгоогоор ялган таньдаг.	Эхийн үндсэн шинжийг бүтцээр нь ялган таньдаг.	Эхийн үндсэн шинжийг бүтэц, баримт-үзэл бодлоор нь ялган таньдаг.	Эхийн үндсэн шинжийг бүтэц, баримт- үзэл бодол, шалтгаан үр дагавраар нь ялган таньж, тодруулдаг.	Эхийн үндсэн шинжийг бүтэц, баримт-үзэл бодол, шалтгаан үр дагавар, таамаглал баталгаа нотолгооны холбоо хамаарлаар ялган таньж, тодруулдаг.

4.2.2. Үнэлгээний нэгж 2. Тайлбарласан эхийн онцлогийг тодорхойлж тайлбарлах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.1б: Учир шалтгааныг тайлбарласан, таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох	Сурагч эхийн сэдэв, гол санааг тодорхойлж чаддаг болсон байна.
9.1в: Зохиогчийн үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, дүгнэлт өгүүлбэрийн уялдаа холбоо, баймж нэгжүүдээр тодорхойлж, тайлбарлах	Сурагч зохиогчийн үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг тодорхойлж, тайлбарлаж чаддаг болсон байна.
9.1д: Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл болон орон, цаг, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлах, тодорхойлох	Сурагч зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлан тодорхойлж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч эхийн сэдэв, гол санааг тодорхойлж чаддаг болсон байна.	Сурагч эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг өгүүлбэрээр тодорхойлдог.
2	Сурагч зохиогчийн үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг тодорхойлж, тайлбарлаж чаддаг болсон байна.	Сурагч зохиогчийн үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, дүгнэлт өгүүлбэрийн уялдаа холбоо, баймж нэгжүүдээр тодорхойлж, тайлбарладаг.
3	Сурагч зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлан тодорхойлж чаддаг болсон байна.	Сурагч баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл болон орон, цаг, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлан тодорхойлдог.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг өгүүлбэрээр тодорхойлдог.	Суралцагч эхийн гол санааг түлхүүр үгээр тодорхойлдог.	Суралцагч эхийн сэдэв, гол санааг түлхүүр үгээр тодорхойлдог.	Суралцагч эхийн сэдэв, гол санааны аль нэгийг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлдог.	Суралцагч эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрийн аль алинаар тодорхойлдог.
Сурагч зохиогчийн үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, дүгнэлт өгүүлбэрийн уялдаа холбоо, баймж нэгжүүдээр тодорхойлж, тайлбарладаг.	Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг баймж нэгжүүдээр тодорхойлдог.	Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодол, бичлэгийн өнгө аясыг баймж нэгжүүдээр тодорхойлж, тайлбарладаг.	Зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодол, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, баймж нэгжүүдээр тодорхойлж, тайлбарладаг.	Зохиогчийн , мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодол, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, дүгнэлт өгүүлбэрийн уялдаа холбоо, баймж нэгжүүдээр тодорхойлж, тайлбарладаг.
Сурагч баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл болон орон, цаг, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлан тодорхойлдог.	Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлаж тодорхойлдог.	Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, орон, цаг, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлаж, тодорхойлдог.	Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөлийн аль нэгээр болон орон, цаг, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлаж, тодорхойлдог.	Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл болон орон, цаг, шалтгааны утгат угсруулан холбох бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлаж, тодорхойлдог.

4.2.3. Үнэлгээний нэгж 3. Эхийн үгийн санг харьцуулах

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.1е: Өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг харьцуулан дүгнэх	Сурагч өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг харьцуулан дүгнэж чаддаг болно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг харьцуулан дүгнэж чаддаг болно.	Сурагч өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг ямар үг өгүүлбэрээр илэрч байгааг харьцуулан дүгнэдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг ямар үг өгүүлбэрээр илэрч байгааг харьцуулан дүгнэдэг.	Өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг /дэвшүүлсэн асуудал нь ямар үг, өгүүлбэрээр илэрч байгааг /-г харьцуулан дүгнэдэг.	Өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг /дэвшүүлсэн асуудал, тайлбар, нь ямар үг, өгүүлбэрээр илэрч холбогдож байгаа/-г харьцуулан дүгнэдэг.	Өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг /дэвшүүлсэн асуудал, тайлбар, дүгнэлтүүд нь ямар үг, өгүүлбэрээр илэрч, холбогдож байгаа/-г харьцуулан дүгнэдэг.	Өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг /дэвшүүлсэн асуудал, үзэл бодол, тайлбар, дүгнэлтүүд нь ямар үг, өгүүлбэрээр илэрч, холбогдож байгаа/-г харьцуулан дүгнэдэг.

4.2.4. Үнэлгээний нэгж 4. Асуудал дэвшүүлэн таамаглаж тайлбарлан бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.2а: Асуудал дэвшүүлэн таамаглаж бичихдээ баталж, нотолж, үгүйсгэж бичих 9.2б: Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр асуудал дэвшүүлэн, шалтгаан үр дагаврын холбоог гарган бичих 9.2в: Асуудал дэвшүүлэн, тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг уялдаа холбоотой илэрхийлж бичих 9.2е: Баримтад үндэслэн тайлбарлан бичих	Сурагч асуудал дэвшүүлэн, таамаглаж, тайлбарласан эх бичиж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч асуудал дэвшүүлэн, таамаглаж, тайлбарласан эх бичиж чаддаг болсон байна.	Сурагч байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр асуудал дэвшүүлэн таамаглаж бичихдээ баримтад үндэслэж, баталж, нотолж, үгүйсгэн, тайлбар, үзэл бодол дүгнэлтийг уялдаатай, шалтгаан үр дагаврын холбоог гарган тайлбарлан бичдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр асуудал дэвшүүлэн таамаглаж бичихдээ баримтад үндэслэж, баталж, нотолж, үгүйсгэн, тайлбар, үзэл бодол дүгнэлтийг уялдаатай, шалтгаан үр дагаврын холбоог гарган тайлбарлан бичдэг.	Байгаль нийгмийн аль нэг сэдвээр асуудал дэвшүүлэн таамаглаж, баримтад үндэслэн бичдэг.	Байгаль, нийгмийн аль нэг сэдвээр ‘-асуудал дэвшүүлэн, таамаглаж, ‘-баримтад үндэслэн, ‘- баталж, нотолж, үгүйсгэн бичдэг.	Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр ‘-асуудал дэвшүүлэн, таамаглаж ‘-баримтад үндэслэн, ‘- баталж, нотолж, үгүйсгэн, ‘-шалтгаан, үр дагаврын уялдааг гарган бичдэг.	Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр ‘-асуудал дэвшүүлэн, таамаглаж, ‘-баримтад үндэслэн, ‘- баталж, нотолж, үгүйсгэн, ‘-шалтгаан үр дагаврын уялдааг гарган , ‘-тайлбар, үзэл бодол дүгнэлтийг холбоотой илэрхийлж бичдэг.

4.2.5. Үнэлгээний нэгж 5. Найруулгын алдаагүй бичих

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.2г: Ойролцоо, эсрэг ойлголтыг жишин харьцуулан дүгнэх, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ тохирох холбоосоор холбох найруулах 9.2д: Орон, цаг, зорилго, шалтгааны утгатай холбох үг, нөхцөл ашиглан угсарсан нийлмэл өгүүлбэрийг зохион найруулж бичих	Сурагч тайлбарласан эх, өгүүлбэрээс найруулгын алдааг таньж, найруулгыг сайжруулах

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч тайлбарласан эх, өгүүлбэрээс найруулгын алдааг таньж, найруулгыг сайжруулах	Сурагч ойролцоо, эсрэг ойлголтыг жишин харьцуулан дүгнэж, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ орон цаг шалтгааны утгатай холбох үг, нөхцөл ашиглан найруулж бичдэг. Сурагч тайлбарласан эх өгүүлбэрээс үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг алдааг таньж , найруулгыг сайжруулдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч ойролцоо, эсрэг ойлголтыг жишин харьцуулан дүгнэж, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ орон цаг шалтгааны утгатай холбох үг, нөхцөл ашиглан найруулж бичдэг.	Учир шалтгааныг тайлбарлан бичихдээ шалтгааны утгатай холбох үг, нөхцөл бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр ашиглан бичдэг.	Эсрэг ойлголтыг харьцуулан дүгнэж, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ орон, цаг, шалтгааны утгатай холбох үг, нөхцөл бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр ашиглан бичдэг.	Ойролцоо ба эсрэг ойлголтын аль нэгийг жишин харьцуулан дүгнэж, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ орон, цаг, шалтгааны утгатай холбох үг, нөхцөл бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр ашиглан найруулан бичдэг.	Ойролцоо ба эсрэг ойлголтыг жишин харьцуулан дүгнэж, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ орон, цаг, шалтгааны утгатай холбох үг, нөхцөл бүхий угсарсан нийлмэл өгүүлбэр ашиглан найруулан бичдэг.
Сурагч тайлбарласан эх өгүүлбэрээс үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг алдааг таньж, найруулгыг сайжруулдаг.	Тайлбарласан эх өгүүлбэр дэх найруулгын алдаанаас цөөхнийг таньж, найруулгыг сайжруулдаг.	· Тайлбарласан эх өгүүлбэр дэх найруулгын алдаанаас заримыг таньж, найруулгыг сайжруулдаг.	· Тайлбарласан эх өгүүлбэр дэх найруулгын алдаанаас ихэнхийг таньж, найруулгыг сайжруулдаг.	· Тайлбарласан эх өгүүлбэр дэх найруулгын алдааг бүгдийг таньж, найруулгыг сайжруулдаг.

4.2.6. Үнэлгээний нэгж 6. Цэг, цэглэлийг хэрэглэх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.2з: Цэг цэглэлийг хэрэглэх	Сурагч цэг цэглэлийг оновчтой хэрэглэж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч цэг цэглэлийг оновчтой хэрэглэж чаддаг болсон байна.	Сурагч цэг цэглэлийг зөв хэрэглэн бичдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч цэг цэглэлийг зөв хэрэглэн бичдэг.	Цэг цэглэлээс цөөн хэдийг хэрэглэдэг.	Цэг цэглэлийг заримыг зөв хэрэглэдэг.	-Цэг цэглэлийн ихэнхийг зөв хэрэглэдэг.	Цэг цэглэлийг бүгдийг нь зөв хэрэглэдэг.

4.2.7. Үнэлгээний нэгж 7. Үзэл бодлоо илэрхийлэх

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
9.3а: Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлаар баримтад үндэслэн баталж, нотолж, үгүйсгэн үзэл бодлоо илэрхийлэх	Сурагч нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлаар үзэл бодлоо илэрхийлж чаддаг болсон байна.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлаар үзэл бодлоо илэрхийлж чаддаг болсон байна.	Сурагч нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлаар баримтад үндэслэн баталж, нотолж, үгүйсгэн үзэл бодлоо илэрхийлдэг.

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлаар баримтад үндэслэн баталж, нотолж, үгүйсгэн үзэл бодлоо илэрхийлдэг.	Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлыг баримтад үндэслэн илэрхийлдэг.	Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлыг ‘-баримтад үндэслэн ‘- баталж, нотолж илэрхийлдэг.	Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлыг ‘-баримтад үндэслэн ‘- баталж, нотолж, ‘-үгүйсгэн илэрхийлдэг.	Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлыг -баримтад үндэслэн, ‘- баталж, нотолж, ‘-үгүйсгэн, ‘- үзэл бодлоо илэрхийлдэг.



“ЕБС-ийн Монгол хэлний хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулсан ажлын хэсэг:

Ш.Оюунцэцэг	БМДИ-ийн зөвлөх
Ц.Март	11-р сургуулийн багш, зөвлөх
М.Болдсайхан	БҮТ, Шалгалт судалгаа хариуцсан хэлтсийн дарга
Д.Энхжаргал	БҮТ-ийн ахлах мэргэжилтэн, магистр
Т.Отгон-Эрдэнэ	БҮТ-ийн мэргэжилтэн, тэргүүлэх
О.Батмөнх	39-р сургуулийн багш, тэргүүлэх, магистр
Н.Батбаяр	33-р сургуулийн багш, тэргүүлэх, магистр
И.Сансартуяа	“Сант” сургуулийн багш

Хөндлөнгийн шинжээч:

Ө.Цэндсүрэн	Монгол улсын гавьяат багш
-------------	---------------------------

Техникийн редактор:

Т.Отгон-Эрдэнэ	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн
----------------	---

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

Э.Сансартуяа	“Хас дизайн пресс” ХХК-ийн дизайнер
Л.Алтансүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Энхтайваны өргөн чөлөө, Арслантай гүүр
“ОЮУНЫ УНДРАА” группийн байр

Утас: 70119498, 70118485
И-мэйл: info@eecs.mn